



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/195

Ховд

Архивын хэлтсийн бүтэц, орон тоог
батлах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.2.12 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 240, 2025 оны 37 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 37 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагт шинээр батлагдсан Архивын хэлтсийн бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж Архивын хэлтсийн албан хаагч, ажилтнуудын ажлын чиг үүргийг тодорхой болгож, албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, батлуулах, үйл ажиллагааны төсөв, цалингийн санг хууль тогтоомжийн хүрээнд шилжүүлэн батлуулах ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Баасанхүү), Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Батсайхан) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Энхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.АМАРСАНАА

8400001 0563

Zah A/195 Och

Засаг даргын 2025 оны
03 дугаар сарын 27-ны өдрийн
А/195 дугаар захирамжийн хавсралт



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ
АГЕНТЛАГ АРХИВЫН ХЭЛТСИЙН БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаалын нэр	Орон тоо	Албан тушаалын зэрэглэл
1	Хэлтсийн дарга	1	ТЗ-4
2	Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын байцаагч	1	ТЗ-7
3	Сан хөмрөгч	1	ТҮМ-4
4	Зааварлагч-арга зүйч	1	ТҮМ-5
5	Сэлбэн засагч-архивч, баримт ариутгагч	1	ТҮМ-5
6	Архивч	1	ТҮМ-5
7	Мэдээллийн технологийн ажилтан	1	ТҮМ-6
8	Цахим сангийн операторч	2	ТҮ-4
9	Нягтлан бодогч	1	ТҮМ-6
10	Үйлчилгээний ажилтан	1	ТҮ-1
11	Харуул хамгаалалтын ажилтан	3	ТҮ-1
Нийт		14	

-оОо-